



**ТӨВ АЙМГИЙН
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
2017 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Аудитын тайлан

Төв аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, Тэргүүлэх аудитор
Ц.Хишигжаргал
Утас: 70272582

И-мэйл: khj_616@yahoo.com

Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273463
И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Аудитор: Д.Бямбасүрэн
Утас: 70272287
И-мэйл:
davaasambuу_byambaa@yahoo.com

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн Аудитын газрын хаяг:
Төв аймаг Зуунмод сум 6-р баг
Төр захиргааны 2 дугаар байр
Цахим хуудас: tuv@audit.gov.mn

2018 оны 03 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд / ТӨВ-2018/6/СТА-ТШЗ / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 02 дугаар сарын 25-наас 2018 оны 03 дугаар сарын 25-ныг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн Төв аймаг дахь Төрийн аудитын газрын санхүүгийн аудитын багийн гишүүн аудитор Д.Бямбасүрэн хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны төсвийн санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 25-нд Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Төв аймаг дахь Төрийн Аудитын газар аудитыг 2018 оны 02 дугаар сарын 25-наас 2018 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 23-нд Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дүгээр зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 6.2.-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38 –д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг хэлнэ гэж заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталж, Төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 9 асуудал эрсдэл өндөр, 3 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 15 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 5 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газар нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд СИТХ-ын 2016 оны 12 сарын 15-ны өдрийн 04 тоот тогтоолоор 310399.0 мянган төгрөг, 2017 оны 06 дугаар сарын 15-нд тодотгож 365247.1 мянган төгрөг, 2017 оны 12 сарын 04 тоот тогтоолоор дахин тодотгож 373047.1 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд 465337.6 мянган төгрөгийн орлогын, 465337.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийж үлдэгдэлгүй байна

Шилэн дансны мэдээлэл:

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газар нь 2017 оны 10 сард хийгдсэн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгах нийцлийн аудитаар мэдээлбэл зохих мэдээллээ 25% оруулсан байна.

Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн "Нийт орлого" -ыг сонгов.

Төсвийн байгууллага нь төсвийн хөрөнгийг төсвийн хуулийн дагуу зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах үүрэгтэй бөгөөд энэ нь санхүүжилт, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын дүнгээс хэтрэхгүй тул суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгон авсан болно.

Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2017 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлого 465337.6 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь 9306.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 8 чиглэлээр

8 эрсдэлтэй асуудалд 8 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 37.5 хувь буюу 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Үр дагавар Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлыг шалгасан болно.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 63707.2 мянган төгрөгөөр дутуу бодогдож санхүүгийн тайлангийн үр дүнгийн зардалд татагдсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3-т “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт мөрдөнө” гэсэн заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залрууллаа.

2. Санхүүгийн тайлангийн үр дүнгийн үйл ажиллагааны зардалд цалингийн зардал 2194.2 мянган төгрөг, ндш 147.2 мянган төгрөгөөр, эд хогшил 2046.2 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж бараа материалын зардлыг хооронд нь 27.5 мянган төгрөгөөр, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг хооронд нь 315.0 мянган төгрөгөөр тус тус гүйлгэж, бараа үйлчилгээний зардлыг 61980.2 мянган

төгрөг, урсгал шилжүүлэг 1727.0 мянган төгрөгөөр нийт 68437.3 мянган төгрөгийн зардлын ангиллыг буруу сонгож тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3-т “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт мөрдөнө” гэсэн заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залрууллаа.

3. Тайлант онд төрийн албан хаагчдад олгох мөнгөн урамшууллын зардлаас сахилгын шийтгэл авсан 3 хүнд 656.7 мянган төгрөг олгосон нь Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 52 дугаар хуралдааны тэмдэглэлд "Улсын их хурлын 67 дугаар тогтоолын дагуу 2017 онд төрийн өндөр дээд албан тушаалтан, шүүгч, прокурор, бусад төрийн албан хаагчид 300000 олгох тухай асуудлыг хэлэлцээд сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэл тооцох хугацаа нь дуусаагүй байгаа албан хаагчаас бусад төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох арга хэмжээ авахыг Төсвийн шууд захирагч нарт даалгав." гэснийг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт бичихээр шийдвэрллээ.

Материаллаг бус зөрчил аудитын явцад илэрээгүй байна.

**Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын
талаарх тайлбар:**

Аудитын явцад материаллаг бус залруулагдаагүй алдаа байхгүй.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн
нэгтгэл:**

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 132801.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 132144.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 656.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт бичлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн хариуг албан бичгээр Төв аймаг дахь Төрийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

“Зөрчилгүй санал дүгнэлт”

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан .9.. хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.БЯМБАСҮРЭН

Огноо: 2018.03.22